

IV. Монголын ойрхи түүхийн асуудлууд

МАНЖ ЧИН УЛСЫН ШИНЭ ЗАСГИЙН БОДЛОГО,
ТҮҮНИЙГ ЭСЭРГҮҮЦСЭН НЭГЭН БАРИМТ

Д.Гомбосүрэн
Цэргийн түүх судлалын төв

Өгүүллийн товч утга. Манж Чин улс Гадаад Монголын талаар явуулж ирсэн бодлогоо XIX-XX зууны завсараар эрс өөрчилж, шинэ засгийн бодлогыг Халхад тулган хүлээлгэхийг оролдох болжээ. Манжийн эл колонийн бодлогыг Монголын ихэс дээдэс, засаг захиргаа хэрхэн эсэргүүцэж байсныг Сэцэн хан аймгийн Дайчин жонон вангийн хошууны жишээн дээр харуулахыг энэ өгүүлэлд хичээв.

Түлхүүр үг. Манж Чин улс, Гадаад Монгол, шинэ засгийн бодлого, 14 зүйл байцаалт, Сэцэн хан аймаг, Улсад туслагч гүн Түмэнтогтох (Хөвчийн дайчин жонон ван)-ын хошуу, 14 зүйл байцаалтын тодорхойлолт

Манж Чин улс XX зууны эхээр Гадаад монголын талаар явуулсан бодлогоо эрс өөрчилж шинэ засгийн бодлого гэгчийг тулган хүлээлгэх болжээ. Тэгээд 1907 оны хавар Гадаад Монголын Төрийг засах явдлын яам (ГМТЗЯЯ), Цэргийн зөвлөлийн яам нэр хавсран гадаад засаг олон монгол аймгийн чуулган дарга нар болон хотон аймгийн ван, гүн нарт тушааж 14 зүйлийг байцаалгажээ. Эрдэмтэн Л.Жамсран абагуйн дүгнэснээр Чин Улс энэ байцаалтаас шинэ засгийн бодлогыг хэрэгжүүлэх бололцоог урьдчилан судлах мэдээ сэлтийг орон нутгаас гаргуулж авах гэсэн төдийгүй уг бодлогод Монголын засаг ноёдоос эхлээд бусад эрх баригчид хэрхэн хандахыг бас туршин мэдэх зорилготой байжээ¹.

Энэхүү 14 зүйл байцаалтад Халхын Дорно замын дундад дахь умард этгээдэд орших Сэцэн хан аймгийн улсад туслагч гүн Түмэнтогтох (Хөвчийн дайчин жонон вангийн)-ын хошуунаас Бадаргуулт төрийн гучин гуравдугаар (1907) он хаврын сүүл сарын хорин есөнд гаргасан тодорхойлолтод хэрхэн хариулсаныг хойно үзнэ. Дашрамд дээрх 14 зүйл байцаалтыг найр тавин өгсөн профессор Ж.Урангуад талархал илэрхийлье.

Иймээс засаг Түмэнтогтох агсаны хошууны нутаг дэвсгэр, хүн ам, мал сүргийн тоо хийгээд байгалийн баялаг, ер нь энэ хошууны эзлэх байр, эдийн засгийн хүч чадлыг товч гаргах нь зүйтэй юм.

Хөвчийн жонон гүн (бэйс, ван)-ий хошуу хэмээн Халх даяар алдаршсан тус хошууг 1689-1692 онд байгуулж, өмнө талаараа Сэцэн хан, Мэргэн гүн, баруун өмнө, баруун талаараа Дархан бэйл, хойд талаараа Түшээт хан аймгийн орос зүгийн харуул, зүүн хойд, зүүн талаараа Эрдэнэдалай вангийн зэрэг 4 хошуутай зах нийлдэг Сэцэн хан аймгийн 23 хошууны 7 засаг хошуу, Түшээт хан аймгийн орос зүгийн 7 харуултай хилийн дээс залгах Халхын том хошуу юм. Харъяат хошууны өмнө этгээд Саригийн баруун гүвээний овооноос эрслэн хойд этгээд Уулинтын эхний нурууны овоо хүртэл 260 газар*, зүүн этгээд Чулуут толгойн овооноос баруун этгээд Баян-Өндөр уул хүртэл 310 газар болмой. Өөрөөр хэлбэл өмнөөс хойд цэг нь 149,8 км, зүүнээс баруун тийш 178,6 км ой хөвч, ойт хээр голлосон өргөн уудам нутагтай, ан амьтан, байгалийн баялаг арвин, Онон, Барх, Эг, Хурх Балж зэрэг гол мөрөн, нуур цөөрөм, булаг шандаар элбэг тансаг сайхан нутаг билээ.

Жамсран Л. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. УБ., 1992. 23 дахь тал нэг газар 576 м

нийлдэг, гадаад улстай хил залгадаг эсэх Худалдааны иргэд хэд, хашаа хүрээ бий эсэх, ямар газар гадаадын хүмүүс голлон худалдаалдаг буюу худалдвал ашигтай, цаашид худалдаачдыг хэрхэн ирүүлэх Хятадын аль мужаас худалдаачин, цэрэг иргэн ирэхэд тохиромжтой их зам буй эсэх, яаравчлан төмөр зам байгуулбал хаанаас залгаж тавих зэргийг байцаажээ.

хойдох өртөө, орос зүгийн харуулд гаргаж суулгасан зэвсэгтэй цэрэг эр дөчин нэг (41), алба туслах хуяг эр дөчин нэгийг (41) тайлаад нутагт үлсэн зэвсэгтэй цэрэг хорин нэг (21) д цэрэг тутамд олбог товь саадаг хоромсого нум нижгээд, арван цэрэг тутамд бүрэн хэрэглэлтэй урт богино буу дөрөөд, жад сэлэм гурваад, буут цэрэг тутам сөд сум арваад, зэв сум гучаадыг бэлтгэжээ. Жил бүр харъяат засаг туслагч түшмэд нүдэн үзэж морин дээр дөчин нумын газар гурав буудах, гучин нумын газар гурав харвах, жадлах, сэлмээр цавчих зэргээр боловсруулан сургаж, харъяат аймгийн Да жанжины хэбэй дарцаагаар бие тулж данс муулан байцаан үзэж хууль дүрэм дор нийлүүлэн тус тусын хязгаарыг сэргийлүүлэн буй хүртэх цалин аму үгүй, харъяат албаны зарлага хуяг арван нэг (11), хязгаарыг тойрон суулгаж цагдан сэргийлүүлсэн зэвсэг үгүй цэрэг хорин хоёр (22), эдний бүл хүмүүн гучин хоёр (32), хөнгөн ялт хулгай тавыг сахих дарга хуяг арав (10), үүнээс дээш албанд гаргасан цэрэг, туслах бүл хүмүүн дарга хуягуудын дотроос бие барсан ба өвдсөн нөгцсөн алба хөрөнгийн морь малаар ядуурсныг цөм халж орон цэрэг дор идэр эрүүдээр нөхөж өрх хөрөнгийн хамтаар нүүлгэж уг албыг хаалгаж залруулан шийтгэсээр буй. Жич дарангуй газар дарангуй цэрэг үгүй. Манай нэгэн хошуу язгуураас сургууль тэнхим байгуулсангүй, харъяат засгийн тамгын газар хэмээх нэгэнийг байгуулаад хууль ёсоор талбисан туслагч тайж хоёр, хошууны захирагч занги, мэйрэн, залан нэжгээд, сумын занги хоёрыг жил бүр цаг дараалан суулгаж, харъяат засгийн хамт элдэв албаны хэрэг зүйлийг шийтгэлцүүлэн, басхүү эд нарыг сургагч болгон сургуулийн нэг хоёр хөвгүүнийг авч монгол бичгийг сургах ба мөн нэгэн хөвгүүн нь Хүрээний сайдуудын сургуулийн гэр дор оруулж манж хятад бичиг үг сургаж буй амой, өөр хичээл чадлыг сургаж чадах ба сурах хөвгүүд үгүй. Харъяат захирсан хязгаарын дотор тус хошууны хэргийн тул байгуулсан өртөө үгүй, гагцхүү харъяат аймагт нийгэмчлэн нэгдэж хошуунаас олон замын өртөө харуул цагдаа хавсаргын зэрэг албан дор гаргаж суулгасан өрх цэрэг олон ч нь болбоос Чуулалт Хаалга, Улиастай хоёр газрын хооронд байгуулсан харчин чухам Тамилант хэмээх төгрөг өртөөний цагдаа дор өрхийн цэрэг нэг, мөн Бөрцөгийн өртөөний цагдаа дор өрх цэрэг нэг, халхын хорь гаруйтай өртөөний хавсарга дор өрх улаач хоёр, Уртын хартолгой өртөөнд өрх цэрэг найм, Хүрээний өмнөх Сонсголонт өртөөнд өрх цэрэг хоёр, Баясгалант өртөөнд өрх цэрэг нэг, Хүрээний хойдох Хиагт замын Дэрстбулаг өртөөнд өрх цэрэг хоёр, Орос зүг байгуулсан Агац харуулд өрх цэрэг долоо, Хирхон харуулд өрх цэрэг дөрөв, Хүмүл харуулд өрх цэрэг гурав, Хисалог харуулд өрх цэрэг дөрөв, Гүе харуулд өрх цэрэг зургаа, Минж харуулд өрх цэрэг хоёр, харъяат аймгаас Улиастай зүг байгуулсан суман Дэглэй өртөөнд өрх улаач нэг, мөн Харчулуут өртөөнд өрх улаач нэг, Хүрээ зүг байгуулсан Да жанжны суман Баянзүрх өртөөнд өрх улаач хоёр, мөн Цагаанчулуут өртөөнд өрх улаач нэг, мөн Ганцхүйтэн өртөөнд өрх улаач гурав, мөн Дүгэржаргалант өртөөнд өрх улаач хоёр, мөн Шинэбулаг өртөөнд өрх улаач нэг, мөн Гайхамшиг өртөөнд өрх улаач нэг. Хан Хэнтий уулын сэтэртэн сүрэг адуулах өрх хуяг нэг, уяа агт адуулах хуяг өрх нэг, бүх оноосон өртөө цагдаа хавсарга харуулын өрх цэрэг улаач хуяг дөчин хоёр (42), харъяат нутгаас алсалсан хол газар дор байгуулсан олон замын өртөө харуул цагдаа хавсаргаар хэдэн газар болохыг төсөвлөж мэдэхгүй, харин Халхын хорин өртөөний цэрэг тутам жил бүр мөнгө хорин таван лан хоёр цэн, Хүрээний өмнөх өртөөний цэрэг тутамд жил бүр мөнгө арван найман лан, хонь дөрөв, аму нэг дан, мөн Хүрээний хойдох өртөөний цэрэг тутам жил бүр мөнгө есөн лан, хонь дөрөв, Хиагтын зүүн этгээд харуулын цэргийг гурван жил эндэгдэлгүй болбоос хүмүүн бүрт нарийн хөх бүс нижгээд хос, үнэ мөнгө нэг лан, чулуун цай хошоод хэсэг, нэг бүр үнэ мөнгө хоёр цэн, шар тамга нижгээд хомил боодол, үнэ мөнгө нэг цэн, хүн бүрд таацуулсан мөнгө нэг лан таван цэн, ийнхүү тус тусаар шагнаж цалин идүүлмой. Үүний дотор харъяат хошуунаас маш бөглүү хол нутагтай өрх цэргийн нэгэн өрх тутам өдөр бүр хошоод лан мөнгө ацаг өгч төлөглөн тохинуулахад мөнхүү өрх тутам дор нийлүүлэн өгөх мөнгө долоон зуун хорин лан дор хүрмой. Харъяат хошууны хязгаарын зүүн баруун, умар өмнө зүг захын хэмжээ, зах нийлэх хошууд ба Түшээт хан аймгийн орос зүгийн Гүе зэрэг долоон харуул лугаа холбосон зэрэг газрыг тухай зураг зурж цуудас наалдуулж үйлдсэнээс гадна гадаад улс лугаа зах нийлсэн газар үгүй. Худалдааны иргэн байгуулсан хороо үгүй, бас гадаад улсын хүмүүн худалдаалан явсан удаа үгүй, гагцхүү Нийслэл хотын харъяат иргэн Лю Хуа Чу хэмээх манж, иргэн Ван Бун Ши хэмээх Буянзаяа, иргэн Ян Да Жүн хэмээх Баянмөнх, иргэн Жан Син Мин хэмээх Буянжаргал, иргэн Му Гү Юй хэмээх Баянсан, иргэн Жан Жи Цун хэмээх Даш, иргэн Ван Жун хэмээх Наст, иргэн Ян Чин Дан хэмээх Төгс, иргэн Сүн Тин Гүй хэмээх Буянт, иргэн Лин Хуан Янь хэмээх Баяр, иргэн Ван Ру хэмээх Баянсан, иргэн Ян Да Юань хэмээх Баянжаргал, иргэн Ван Хун хэмээх Буянт, иргэн Ава Янь хэмээх Наст, Долон нуурын харъяат Лю Чи Чин хэмээх Зургаадай, иргэн Та Шан Чу хэмээх Ажиндай эдгээр иргэд Хүрээний зургааны занги бүхнийг мэдэгчийн яамнаас хоёр зуун өдрийн хуучны тэмдэгт бичиг авч жил бүр нэг хоёр удаа цай бүсийн зэрэг юм тээн ирж мал, арьс шир, хонины унгас зэрэг зүйлийг харилцан худалдаалан авч хойш буцахаас өөр хойч өдөр хэрхэн аргаар элсэж хурилцах ба харилцан худалдаа хийх зэрэг сайн газар үгүй. Харъяат хязгаарын дотор хэдийнээс чухал их зам аль ч мужид огт нэвтэрсэнгүй ба одоо худалдааны хүмүүн иргэн, цэрэг нийлүүлэн нэвтрэхэд тус болгох төмөрт зам утасны шувгааг үйлдэх ба зангилдааны байгуулах газар үгүй.

Эл 14 зүйл тодорхойлсон зүйлийг үндэслэн доорх гаргалгаа, дүгнэлт хийж болно.

Нэгд, эдийн засгийн гол үзүүлэлт малын тоо толгой, тарианы газрын хэмжээ, хятад иргэдээр атар газрыг хагалбарлуулж болох эсэх, малаас гарах түүхий эдийг боловсруулах үйлдвэр нээх [байцаалтын §1. 2. 5.]

Тус хошууны өрх, амын тоо, малын тоог 1907 онд гаргасан дээрх тодорхойлолтод заасныг 1918 оны хүн ам, мал тооллогын данс (И.Майский)-тай харьцуулбал:

Он	Өрхийн тоо	Амын тоо	Малын тоо				Бүгд
			Адуу	Тэмээ	Үхэр	хонь	
1907	905	4053	11541	182	6867	104991	123600
1918	1786	6121	29564	544	20093	49999	100200
Зөрүү	+881	+2068	+17993	+362	+13226	+54992	23411

Хүснэгтээс үзвэл 12 жилийн дотор тус хошуунд хүн ам, малын тоонд ихээхэн өөрчлөлт гарсан мэт харагдаж байна. Үүнийг тайлбарлахыг оролдъё.

1907 онд гаргасан тодорхойлолтод уламжлал ёсоор харъяат засаг ноёны өрх ам, малын тоо ороогүйн дээр зөвхөн “аливаа албан дагаваас зохих туслагч, тайж, харц хүмүүний ам, өрх, эдний өөр өөрийн амин хүчнээр үржүүлсэн” малыг оруулсан нь тус хошууг ядуулаг харагдуулахыг хичээсэн хэрэг, өөрөөр хэлбэл ядуус болох “амь ульжих” өрх ам, тэдний малыг дарсан байна. Иймээс 1918 онд өрх ам, адуу, тэмээ, үхэр ихээхэн нэмэгдсэн мэт буй юм.

Харин хонины тоо 1918 онд (энэ онд ямааг малын тоонд оруулсныг тооцвол) 54992 толгойгоор буурсныг тайлбарлахад бэрх агаад үнэмшил туйлын муутай бөгөөд статистикийн алдаа бололтой. Эндээс Манж Чин улсын байцаалтад гаргасан тодорхойлолтод малын тоог ихээхэн даржээ хэмээн дүгнэж болно.

Тариа хагалах газар огт байхгүй.

Малаас гарах түүхий эдийг зарим нэг хүмүүн “... худалдааны иргэнд (хятад) худалдаж албыг залгамжлуулан, амисыг тэжээмэй” гэсэн нь хятад худалдаачид нэгэнт монголын түүхий эдийн зах зээлийг эзэмшиж, бид тэдэнд алба залгуулдаг тул цааш өнгөлзөх хэрэггүйг сануулсан гэлтэй.

Хоёрт, газар нутгийн хэмжээ, газрын дээрх ба доорх байгалийн баялаг, түүнээс олох ашиг-ой мод, ан гөрөөс, загас агнуур, давс хужир, газрын доорх ашигт малтмал г.м. [байцаалтын §3, 4, 6, 7, 8, 12] асуудал Манж Чин улсын сонирхолыг ихээхэн татаж байв.

Байцаалтад хошууныхаа нутаг дэвсгэрийн хэмжээг үнэн зөвөөр гаргасан боловч байгалийн баялгаа огт үгүйсгэсэн байдаг. Жишээлбэл: “нэрт их уул үгүй” өчүүхэн бага харгана ургана, “гахай, зүр”-ийн албыг жил тутам төлсөөр бараг байхгүй болсон, дутагдах анг Их Хүрээний газраас худалдан авдаг, харъяат нутгийн дотор ямар ч уурхай байхгүй, гагц Онон гол байвч маш ширүүн урсгалтай тул загас ер байдаггүй, язгуураас давст нуур байхгүй” хэмээн тодорхойлсон байна.

Гуравт, Манж Чин улсын албыг залгуулах чадвар: хошууны цэрэг зэвсгийн тоо, өртөөний алба, хүмүүсийн тоо, зардал, сүйтгэл [байцаалтын §9,11]. Энэ бол эзэнт гүрний сонирхолыг байнга татаж байдаг, монголчуудын хувьд маш хүндээр тусаж ирсэн хоёр төрлийн хүнд хүчир алба юм.

Эндээс Манжийн эрхшээлийн үеийн монголын цэргийн зохион байгуулалт, алба хаах журам, цэргийн сургууль бэлтгэл, зэвсэглэл зэргийг мэдэж болно. Тус хошуу нэг сум (эскадрон) илүү, өөрөөр хэлбэл (150+36) 186 цэрэг гаргах үүрэгтэй байж, үүнээс гуравны нэг буюу 62 нь зэвсэгтэй, үүний 41 цэрэг орос зүгийн харуулд, 21 нь орон нутагтаа байж, жил бүр цэргийн сургуульд хамрагддаг байсныг тодорхой өгүүлжээ. Үлдэх зэвсэггүй хуяг цэрэг 124 байхаас орос зүгийн харуулд алба туслах

хуяг 41, хошууны нутагт (зарлага, зах хязгаар суух, эдний бүл, гяндангийн харгалзагч) 75 бүгд 116 хуяг эр алба хааж байжээ.

Бүгд $62+41+75=178$ цэрэг эрийн алба мэдэгдэж байгаа бөгөөд $186-178=8$ цэргээр зөрж байна. Өртөө, харуулын албаны тухайд энэ хошуунаас Алтай замын Халхын 20 ба харчин 20 өртөө, Хүрээний өмнөх болон Хүрээ Хиагтын өртөө, Сэцэн хан аймгаас Улиастай хүртэл байгуулсан, мөн Хүрээний зүг байгуулсан Да жанжны суман өртөөнд өрх цэрэг 15, өрх улаач 14, орос зүгийн харуулд өрх цэрэг 26, сүрэгтэн өрх хуяг 2 бүгд 57 өрх алба хааж байсан нь мэдэгдэнэ. Харин тодорхойлолтод бүгд 42 гэжээ. Энд 12 өрхөөр зөрж байна.

Дөрөвт, худалдааны иргэд, пүүс салбарын тоо, хятадын аль мужаас худалдаачин, цэрэг иргэн ирэхэд тохиромжтой зам буй эсэх, төмөр зам байгуулах боломж [байцаалтын §13, 14]. Энд Их Хүрээнээс ирж арилжаа наймаа эрхэлдэг 16 худалдаачдын нэрийг дурдаад цаашид худалдааны суурин газар байгуулах боломжгүй, бас зам харилцааны хувьд төмөр зам, утасны шугам байгуулах газар байхгүй хэмээн тодорхойлжээ.

Тавд, сургууль бий эсэх, сургагч багш, сурагчид хэд [байцаалтын §10]-ийг тодорхойлуулахаар заасан нь өнгөн дээрээ монголчуудын эрдэм боловсролд тустай мэт ганц байцаалт боловч цаад утга нь Манжийн төрд үйлчлэх хүмүүсийг судлах, бэлтгэх гэсэн оролдлого байв.

Энэ бүхнээс үзэхэд Манж Чин улсаас Гадаад Монголд нэвтрүүлэх гэсэн шинэ засгийн бодлогыг Халх даяар эсэргүүцэж байсны тодорхой баримт нь дээр өгүүлсэн 14 зүйл байцаалт, түүнд өгсөн тодорхойлолт (хариулт) мөн хэмээн дүгнэж болно.

Abstract: Later XIX century Manchi Qing government changed its policy on outer Mongolia. Its called "the New government policy". The government tested reactions of Mongolian aristocrats on this policy. Its test includes 14 articles. From Setsen khan aimak-iin Daichin jonon wan-y khoshuu, its governor ulsad tuslagch gun Tumentogtokh gave answers. The document contains its answers and results which shows Mongolian people and aristocrats reaction on the new policy.

Ном зүй

1. Нацагдорж Ш. Манжийн эрхшээлд байсан үеийн Халхын хураангуй түүх. (1691-1911). УБ., 1963
2. Өлзийсүрэн Б. Халхын Сэцэн хан аймгийн хураангуй түүх. Өндөрхаан. 1993.
3. Пүрэвдорж М. Хөвчийн жонон вангийн хошуу хэмээх түүхэн тэмдэглэл. Өндөрхаан. 1993.
4. Гомбосүрэн Д. Хөвчийн жонон ван Цогбадрах. УБ., 2002
5. Манжийн эрхшээлийн үеийн Монгол. (эрдэм шинжилгээний бага хурал). Эрхэлсэн академич Ж.Болдбаатар. УБ., 2004
6. Хэрээд Ж.Урангуа XX зууны эхэн үеийн Монгол Улс (1911-1919). УБ., 2006.
7. Гүн Г.Түмэнтогтох 1903-1907 онд тус хошууны засаг ноён байв. Тэрбээр энэхүү тодорхойлолтыг гаргах үед нас нөгчсөн, дараагийн засаг Тунгалаг (Базарсад) залгамжлаагүй байжээ. ** УТА. ФМ-40. д.1. хн.42^a. нугалбар 1